



**БУЛГАН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/631

Булган сум

**Хүндэтгэл үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамирын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны XXV/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Булган сумын харьяат Цэгмидийн Баттулга нь “Парис 2024” зуны Паралимпийн наадамд бөөрөнцөг түлхэлтээр амжилттай оролцон мөнгөн медаль хүртсэн, мөн Монгол улсын “Гавьяат тамирчин” цолоор шагнагдсан тул 2 өрөө орон сууцаар шагнаж урамшуулсугай.

2. Дээрх орон сууцыг Булган сумын 5 дугаар баг, Д.Дамбын 2 дугаар гудамж, 208-б тоот хаягт байршилтай “Нүнжигт Өргөө” ХХК-ийн барьж буй 20 айлын орон сууцны 2 дугаар давхрын 05 тоотын 56 м2 талбай орон сууцыг 145 600 000 (нэг зуун дөчин таван сая зургаан зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулан худалдан авахыг аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Алтаншагай)-д даалгасугай.

3. Тус орон сууцыг чанар, стандартын дагуу хүлээлгэн өгөхийг “Нүнжигт өргөө” ХХК-ийн захирал Л.Мөнхтөрд даалгасугай.

4. Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6324010861